



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/52/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: О.Алтансүх Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН 11 ДҮГЭЭР Г
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Э.ТУЛГАА ТАНАА

2020.02.27 № 1264

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:/бичиг хэрэг 2020-Албан тоот А4/

005020214

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

-Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, хүнсний тайлан, хоолны меню болон зарлагын баримтыг засварласнаас хоолны нормативт зардлыг 3279,8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, 2019 оны 12-дугаар сарын 16-наас ажлын 8 өдөр хүүхдийн хоолыг батлагдсан менюны дагуу олгоогүй, тээвэр шатахуун болон эм боох бараа материалын нярвын тайлан үнэн зөв гаргаагүйгээс 3251,6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлан гаргасан, жилийн эцсийн тооллогын бүртгэл нь анхан шатны баримтын бүрдлийн шаардлага хангахгүй зэрэг нь тайлант хугацаанд гаргасан хүнсний бүтээгдэхүүний тухайн бараа материалын зарлага, болон үлдэгдэл үнэн зөв эсэхийг нотлох боломжгүй байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

D:/бичиг хэрэг 2020-Албан тоот А4/

2.1. Оршил

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрхлэгч Э.Тулгаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.21-наас 2020.02.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.13-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд эерэг зан чанар, зөв хандлагыг төлөвшүүлэн, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн ACOLOUS болон цалингийн Payroll программ” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 28 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд,” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 406974,7 мянган төгрөгөөс тооцон 8139,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2041,5 мянган төгрөгөөр буюу 0,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	9000,0	9759,5	759,5
Бараа материал	40,361,3	43,651,2	3,289,8
Үндсэн хөрөнгө	864,769,5	866,969,5	2,200,0
Хуримтлагдсан элэгдэл	-67,783,5	-17,467,5	-50,315,9
Нийт хөрөнгө	<u>846,347,3</u>	<u>848,388,8</u>	2,041,5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	846,347,3	848,388,8	2,041,5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>846,347,3</u>	<u>848,388,8</u>	2,041,5

Тайлант онд авлага 759,5 мянган төгрөг нэмэгдсэн нь шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан Пүрэвтогоогийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлснөөс шалтгаалсан байна. Дээрх нийт авлагын дүнд урьдчилгаа авлага 9000,0 мянган төгрөгийн байгаа нь 2018 онд Гэгээн эх ХХК-р склад бариулах гэрээ хийж олгосон баригдаж дуусгаагүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,289,8 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 2525,0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 2200,0 мянган төгрөгөөр өссөн нь Ламын гэгээний 380 жилийн ойн баяр наадмын хандиваас 2019 оны АИТХ-ын Тэргүүлэгчдийн 98 тогтоолоор 2200,0 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ханатай цоохор гэр 1 иж бүрдлийг хандив болгон өгснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 17467,6 мянган төгрөгөөр тайлант оны элэгдлийн зардлаар нэмэгдэж 85251,1 мянган төгрөг болсон байна.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ 770,0 мянган төгрөг, газар 58254,0 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 848388,8 мянган төгрөг болж өмнөх оноос 2041,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70101 хөтөлбөрт зориулан 404192,6 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 343438,0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 60754,6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 404192,6 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь улсын төсвөөс 343438,0 мянга, орон нутгийн төсвөөс 60754,6 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 28 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 18762,5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 12225,1 мянган төгрөгийн 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 6537,4 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Аудитаар дараах 3481,6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1851,6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд

Илрүүлэлт:

1. Хүүхдийн хоолны зардалд 2019 онд нийт 31603 хүүхэд/өдөрт 55424,8 мянган төгрөгийг хоолны зардалд зарцуулсан ба 1 хүүхэд өдөрт дунджаар 1753 төгрөг байгаа нь Засгийн газрын 2012 оны 10 сарын 27 ны өдрийн 106 дугаар тогтоолд заасан "Цэцэрлэгийн

хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 төгрөгөөр олгоно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нормативыг хэтрүүлэн 3279,8 мянган төгрөгийн хүнсний бараа материал илүү зарцуулсан байна. Үүнийг тодруулан шалгахад нярав, нягтлан бодогч нар тайланг засварласан, хоолны өдөр тутмын меню дээр балын харандаагаар хүнсний бүтээгдэхүүнийг нэмж бичсэн, засварласан зэргээс үүссэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайланд оны эцэст 3257,6 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй бөгөөд үлдэгдлийг түүвэрлэж тулгахад хонь, үхрийн мах болон бусад хүнсний бүтээгдэхүүнийг төсөвтэй харьцуулахад их хэмжээгээр авч хүнсний нөөцийг бэлдсэн байгаа нь хадгалалтын хугацаа алдагдах, чанар байдал өөрчлөлт орох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бараа материалын тайлан, Нягтлан няравын зарлагын баримтыг цаг хугацаанд нь баталгаажуулж гаргаж байх. Гаргасан тайлан орлого зарлагыг дэлгэрэнгүй анхаарч үзэх шаардлагатай.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс хугацаанд нь 114 мэдээллийг , 37 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	11	11	9	2		
2	Хагас жил	4	4	3	1		
3	Улирал бүр	1	4	3	1		
4	Сар бүр	3	36	31	5		
5	Тухай бүр	8	96	80	28		
	Нийт	27	151	114	37		

2019 оны тайлант онд дараа жилийн төсвийн төсөл мэдээ, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээний 9, 11, 12 дугаар сар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээний 7, 11-р сар, тухайн жилийн төсөвт нэмэлт өөрчлөлт

орсон мэдээний 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 11, 12-р сарууд, санхүүгийн тайлан мэдээний хагас жилийн мэдээ, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл мэдээний 11-р сар, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн 1, 3-р сар, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэг, хаяг мэдээний 1-8, 11-р сарууд, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ор, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээний 1, 7, 8, 9, 11-р сарууд, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт мэдээний 11 р сар мэдээнүүдийг тус тус хугацаа хоцроосон байна.

Хугацаа хоцроосон тайлбарыг нягтлан бодогчоос авахад алдаатай буруу оруулсан мэдээллийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс шалгаж мэдээллийг засуулж оруулснаас хугацаа хоцроосноор бүртгэгдсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар нярвын тайлан бүрэн гаргаагүй гэсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалтай” дүгнэлт

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор 11 дүгээр цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2019 оны жилийн эцсийн бараа материалын тайланг тулган шалгахад няравын бараа материалын тайлан гаргаагүй болон дутуу гаргасан, гарсан зардлын дагуу тайланг үнэн зөв бэлтгэн боловсруулж гаргаагүй анхан шатны баримтаар БМ-ын журналд шууд бичилт хийсэн, бараа материалын тайлан санхүүгийн тайлан дахь бараа материалын тодруулгаас 3251.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байв.

Энэ нь Үнэн зөв байдал Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд зардал буруу илэрхийлэгдэх өглөг авлага бүрэн тусахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.1, Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалтыг дагаж мөрдөх, Няравын тайлангийн алдаа болоод зөрүүтэй гаргасан тусгай зориулалт, бичиг хэрэг, аж ахуй, тээвэр шатахуун болон гаргаагүй эм боох бараа материалын тайланг дахин гаргаж 2019 оны 4 дүгээр сарын 30-ны дотор хариу ирүүлэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

2018 оны эцэст Гэгээн эх ХХК-р склад бариулах гэрээ хийж олгосон 9000,0 мянган төгрөгийн урьдчилгаа авлага нь ажил дуусаагүй шалтгаанаар барилга баригдаж дуусгаагүйгээс үлдэгдлээр санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

2.2 Эрсдэл:

Хөрөнгө үрэгдэх

2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн авлагыг барагдуулж, Гэгээн эх ХХК-р гэрээнд заасны дагуу ажлыг гүйцэтгүүлж, хүлээн авч 2020:06:01-ны дотор хариу ирүүлэх

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,361,338.26	53,410,743.40
33	АВЛАГА	00.00	759,520.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	759,520.00
34	УРЬДЧИЛГАА	9,000,000.00	9,000,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	9,000,000.00	9,000,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	9,000,000.00	9,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,361,338.26	43,651,223.40
351	Түүхий эд материал	9,138,344.74	10,060,499.90
35110	Тусгай зориулалттай материал	9,138,344.74	10,006,199.90
35130	Эм боох материал	00.00	54,300.00
354	Хангамжийн материал	31,222,993.52	33,590,723.50
35410	Бичиг хэргийн материал	70,000.00	35,700.00
35420	Аж ахуйн материал	00.00	9,000.00
35460	Хүнсний материал	706,050.02	3,231,130.00
35470	Бусад хангамжийн материал	30,446,943.50	30,314,893.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	796,986,002.16	794,978,133.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	796,986,002.16	794,978,133.57
392	Биет хөрөнгө	739,476,335.30	737,494,133.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	722,118,262.98	722,118,262.98
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,964,991.85	36,964,991.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,733,384.81	-29,178,963.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,543,514.92	41,743,514.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,469,177.12	-36,757,562.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,888,740.00	7,888,740.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,836,612.52	-5,284,849.96
393	Биет бус хөрөнгө	57,509,666.86	57,484,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	58,254,000.00	58,254,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-744,333.14	-770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	846,347,340.42	848,388,876.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	846,347,340.42	848,388,876.97
51	Засгийн газрын хувь оролцоо	846,347,340.42	848,388,876.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,346,782,150.50	1,346,782,150.50
51101	Өмч: - төрийн	1,346,782,150.50	1,346,782,150.50
512	Хуримтлагдсан үр дүн	-500,434,810.08	-498,393,273.53
51210	Өмнөх үеийн үр дүн	-500,434,810.08	-500,434,810.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,041,536.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	846,347,340.42	848,388,876.97

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	362,164,054.00	409,016,252.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,149,087.00	3,612,775.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,149,087.00	3,612,775.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,149,087.00	3,612,775.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,149,087.00	3,612,775.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,411,467.00	61,965,477.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	341,603,500.00	343,438,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	60,754,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	60,754,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,367,167.00	1,210,877.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,367,167.00	1,210,877.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	381,851,916.16	406,974,715.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,851,916.16	406,974,715.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,529,767.16	405,283,138.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,009,918.00	237,575,100.00
210101	Үндсэн цалин	163,223,218.00	202,402,779.00
210102	Нэмэгдэл	7,568,300.00	16,942,621.00
210104	Урамшуулал	11,218,400.00	18,229,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,544,600.00	29,453,080.00
210201	Тэтгэврийн даатгал	21,544,600.00	21,885,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,189,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,751,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	770,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,856,380.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,871,800.00	57,954,600.00
210301	Гэрэл, цахилгаан	4,002,100.00	4,088,000.00
210302	Түлш, халаалт	36,665,700.00	36,564,240.00
210303	Цэвэр, бохир ус	17,204,000.00	17,302,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,713,700.00	5,265,669.84
210401	Бичиг хэрэг	536,400.00	578,600.00
210402	Тээвэр, шатахуун	290,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	899,019.00	967,130.00
210404	Ном, хэвлэл	86,700.00	48,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	171,000.00

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	901,581.00	2,483,470.00
210408	Бараа материал ақталсны зардал	00.00	676,969.84
2105	Нормативт зардал	59,037,035.00	56,265,020.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,300.00	30,000.00
210502	Хоол, хүнс	58,217,035.00	55,424,820.02
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	742,700.00	810,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,254,000.00	10,374,000.00
210604	Урсгал засвар	9,254,000.00	10,374,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	168,700.00
210702	Дотоод албан томилолт	00.00	168,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,489,500.00	659,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,489,500.00	409,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,609,214.16	7,567,368.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	138,100.00	3,359,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,664,814.16	4,207,868.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,322,149.00	1,691,577.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,207,467.00	1,691,577.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,367,167.00	1,210,877.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	365,700.00	480,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-19,687,862.16	2,041,536.55
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-489,885,279.28	2,041,536.55

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	348,014,967.00	405,403,477.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	348,014,967.00	405,403,477.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	341,603,500.00	343,438,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	60,754,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	60,754,600.00

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,367,167.00	1,210,877.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,367,167.00	1,210,877.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	348,014,967.00	405,403,477.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,014,967.00	405,403,477.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,692,818.00	403,711,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,009,918.00	237,144,600.00
210101	Үндсэн цалин	163,398,518.00	199,691,472.00
210102	Нэмэгдэл	7,568,300.00	19,223,428.00
210104	Урамшуулал	11,043,100.00	18,229,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,544,600.00	30,643,100.00
210201	Тэтгэврийн даатгал	15,135,833.00	21,885,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,663,900.00	2,189,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,331,100.00	1,751,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	332,700.00	770,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,081,067.00	4,046,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,871,800.00	57,954,600.00
210301	Гэрэл, цахилгаан	4,002,100.00	4,088,000.00
210302	Түлш, халаалт	36,665,700.00	36,564,240.00
210303	Цэвэр, бохир ус	17,204,000.00	17,302,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,475,100.00	4,417,100.00
210401	Бичиг хэрэг	320,900.00	398,000.00
210402	Тээвэр, шатахуун	290,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	899,019.00	967,130.00
210404	Ном, хэвлэл	86,700.00	48,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	171,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	878,481.00	2,492,470.00
2105	Нормативт зардал	59,584,500.00	58,844,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,300.00	84,300.00
210502	Хоол, хүнс	57,289,500.00	57,949,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,217,700.00	810,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,254,000.00	10,374,000.00
210604	Урсгал засвар	9,254,000.00	10,374,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	168,700.00
210702	Дотоод албан томилолт	00.00	168,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,489,500.00	659,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,489,500.00	409,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00

Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,463,400.00	3,505,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	138,100.00	3,505,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,322,149.00	1,691,577.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,207,467.00	1,691,577.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,367,167.00	1,210,877.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	365,700.00	480,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,289,298,150.50	33,157,134.72	1,322,455,285.22
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,289,298,150.50	33,157,134.72	1,322,455,285.22
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-5,216,133.11	-5,216,133.11
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,346,782,150.50	-500,434,810.08	846,347,340.42
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,346,782,150.50	-500,434,810.08	846,347,340.42
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,346,782,150.50	-500,434,810.08	846,347,340.42
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	2,041,536.55	2,041,536.55
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,346,782,150.50	-498,393,273.53	848,388,876.97

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	404,192,600.00	404,192,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,192,600.00	404,192,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,711,900.00	403,711,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,144,600.00	237,144,600.00
210101	Үндсэн цалин	199,538,900.00	199,691,472.00
210102	Нэмэгдэл	19,376,000.00	19,223,428.00
210104	Урамшуулал	18,229,700.00	18,229,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,643,100.00	30,643,100.00
210201	Тэтгэврийн даатгал	21,885,500.00	21,885,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,189,400.00	2,189,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,751,500.00	1,751,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	437,900.00	770,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,378,800.00	4,046,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,954,600.00	57,954,600.00
210301	Гэрэл, цахилгаан	4,084,900.00	4,088,000.00
210302	Түлш, халаалт	36,665,700.00	36,564,240.00
210303	Цэвэр, бохир ус	17,204,000.00	17,302,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,417,100.00	4,417,100.00
210401	Бичиг хэрэг	389,000.00	398,000.00
210402	Тээвэр, шатахуун	340,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	967,100.00	967,130.00
210404	Ном, хэвлэл	90,400.00	48,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	171,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,450,600.00	2,492,470.00
2105	Нормативт зардал	58,844,400.00	58,844,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,300.00	84,300.00
210502	Хоол, хүнс	57,949,900.00	57,949,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	810,200.00	810,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,374,000.00	10,374,000.00
210604	Урсгал засвар	10,374,000.00	10,374,000.00
2107	Томилолт, зочны зардал	168,700.00	168,700.00
210702	Дотоод албан томилолт	168,700.00	168,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	659,600.00	659,600.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	409,600.00	409,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3505800.00	3505800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,505,800.00	3,505,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	480700.00	480700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	480,700.00	480,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	480,700.00	480,700.00

Аудитын тайланг

Хясан:

Тэргүүлэх аудитор  Б.Мөнхбат 2018.02.12

Аудитын менежер  А.Цээням 2018.02.12

Бэлтгэсэн:

Аудитор  О.Алтансүх 2018.02.12

